



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/467

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох комиссын  
бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.3.3, 19.3.4, 19.3.5 дахь заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбоотой Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/61 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/606 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД *С. Энхболд* С.ЭНХБОЛД

141222209

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09  
дүгээр сарын 15 өдрийн 11/15 дугаар  
тушаалын хавсралт



## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга
- Комиссын орлогч дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний ханган нийлүүлэх, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Гишүүд:
- Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтсийн Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан ахлах шинжээч
  - Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын Урьдчилан сэргийлэлт, хяналт зохицуулалтын хэлтсийн Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн
  - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанарын хяналтын газрын дарга
  - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын газрын хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
  - Нийслэлийн эрүүл мэндийн газрын эмийн сангийн тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн /Зөвшилцсөнөөр/
  - Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хэрэглэгчийн эрхийн хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга /Зөвшилцсөнөөр/
  - Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “ЭМ” холбооны тэргүүн /Зөвшилцсөнөөр/